УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2018 оны 07 сарын 10 өдөр Дугаар А/194 Улаанбаатар хот

Б.Гэрэлийг диплом гардуулах
Хүндэтгэлийн арга хэмжээнд
оролцуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аудит дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн Баттулгын Гэрэл нь 2016-2017 онд Сөүл хотын захиргааны тэтгэлгээр Сөүлийн их сургуульд суралцаж, 2018 онд "Хот дахин төлөвлөлт"-ийн чиглэлээр магистрын диплом хамгаалсантай холбогдуулан диплом гардуулах арга хэмжээнд 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийг дуустал хугацаанд оролцуулсугай.

2. Б.Гэрэлд дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдсан хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2018\Тушаал doc 2018.docx

1100300845